

Мөнгөний тойм

2009 оны 12 дугаар сар

1. Үнэ

Үндэсний статистикийн хорооны мэдээгээр 2009 оны 12 дугаар сард хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ улсын хэмжээнд өмнөх сартай харьцуулахад 0.7 хувь, өмнөх оны мөн үеэс 4.2 хувиар өссөн байна. Улаанбаатар хотын хэмжээнд өмнөх сараас 0.2 хувь, өмнөх оны мөн үеэс 1.9 хувиар нэмэгдсэн байна. Хэрэглээний үнийн индексийг ашиглан тооцсон *суурь инфляци* өмнөх сартай харьцуулахад 0.2 хувь, өмнөх оны мөн үеэс 4.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Хэрэглээний барааны үнийн индекс (хувиар)


	Хувийн жин	2009-ХII	2009-ХII
		2008-ХII	2009-ХI
Хүнсний бараа, ундаа, ус	41.08	99.5	100.2
Согтууруулах ундаа, тамхи	2.26	122.1	100.1
Хувцас, бөс бараа, гутал	12.38	103.7	100.3
Орон сууц, ус, цахилгаан, түлш	13.40	96.1	100.3
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	4.30	106.5	99.8
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	1.62	114.2	100.0
Тээвэр	8.71	99.2	100.3
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.05	107.0	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	3.33	101.9	100.6
Боловсролын үйлчилгээ	4.15	109.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлч.	1.72	112.0	100.0
Бусад бараа үйлчилгээ	3.0	115.9	100.0
Ерөнхий индекс	100.0	101.9	100.2

Эх үүсвэр: Статистикийн сарын бюллетень, Үндэсний статистикийн хороо, (Улаанбаатар хотын индекс)

Хэрэглээний үнийн индексээр тооцсон жилийн инфляци Улаанбаатар хотод 2009 оны 12 дугаар сард 1.9 хувиар өссөн нь согтууруулах ундаа, тамхи, боловсролын үйлчилгээ, бусад бараа үйлчилгээ бүлгүүдийн үнэ нэмэгдсэнээс шалтгаалжээ. Ялангуяа янжуур тамхины үнэ 33.7 хувь, дүнсэн тамхиных 52.0 хувь, улсын болон хувийн их дээд сургуулиудын сургалтын төлбөр 7.9-10.3 хувиар өсчээ. Тайлант онд хүнсний бараа, ундаа, ус, орон сууц, ус, цахилгаан, түлш, тээвэр бүлгүүдийн үнэ 0.5-3.9 хувиар буурч, бусад бүлгүүдийн үнэ 1.9-22.1 хувиар өссөн байна.

Хэрэглээний барааны сагсан дахь хамгийн өндөр хувийн жин эзэлдэг хүнсний бараа, ундаа ус бүлгийн (41.1%) үнэ 0.5 хувиар буурсанд хонины махны үнэ 12.0 хувь, үхрийн махных 5.4 хувь, хонины цувдайны үнэ 27.8 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.

Зураг 1. Инфляци



Эх сурвалж: УСХ, Статистикийн бюллетень

2. Мөнгөний нийлүүлэлт¹

2009 оны жилийн эцсийн байдлаар мөнгөний нийлүүлэлтийн хэмжээ 2880.0 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 610.0 тэрбум төгрөг буюу 26.9 хувиар өсчээ. Тайлант онд бараг мөнгө 606.1 тэрбум төгрөг буюу 37.4 хувиар өссөн нь нийт мөнгөний өсөлтөд нөлөөлжээ.

Зураг 2. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт



Эх сурвалж: Монголбанк, Статистикийн бюллетень

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн хурд 9 дүгээр сараас нэмэгдсээр байгаа бөгөөд оны эцэст өмнөх оны мөн үеэс 32.3 нэгжээр өссөн үзүүлэлттэй байна.


2.1 Мөнгөний нийлүүлэлтийн бүрэлдэхүүн

Бараг мөнгө

¹ M2-мөнгөний нийлүүлэлт нь бараг мөнгө, M1 мөнгөний нийлбэр.

Тайлант онд бараг мөнгө өмнөх оны мөн үеэс 606.1 тэрбум төгрөг буюу 37.4 хувиар өсч 2228.8 тэрбум төгрөгт хүрсэн байна. Бараг мөнгөний өсөлтийг бүтцээр нь авч үзвэл төгрөгийн хадгаламж 335.6 тэрбум төгрөг буюу 37.3 хувь, гадаад валютын хадгаламж 181.9 тэрбум төгрөг буюу 41.3 хувь, гадаад валютын харилцах 88.6 тэрбум төгрөг буюу 31.2 хувиар тус тус өсчээ. Бараг мөнгөний өсөлтийн хурд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 47.7 нэгжээр нэмэгджээ.


Зураг 3. M1, M2, Бараг мөнгө (жилийн өөрчлөлт)



Эх сурвалж: Монголбанк, Статистикийн бюллетень

Нийт хадгаламж өнгөрсөн оны мөн үеэс 517.5 тэрбум төгрөг буюу 38.7 хувиар өсч 1856.4 тэрбум төгрөгт хүрсэн байна. Нийт хадгаламжийн 66.5 хувь нь төгрөгийнх, 33.5 хувь нь валютын хадгаламж байна. Төгрөгийн хадгаламжийн нийт хадгаламжинд эзлэх хувь 2008 оны мөн үетэй харьцуулахад 0.6 нэгжээр буурчээ.

Зураг 4. Нийт хадгаламж (жилийн өсөлт)



Эх сурвалж: Монголбанк, Статистикийн бюллетень

Бага мөнгө

Бага мөнгө (M1) өмнөх оны мөн үеэс 3.9 тэрбум төгрөг буюу 0.6 хувиар өсч 651.2 тэрбум төгрөгт хүрчээ. Тайлант онд банкнаас гадуурх мөнгө өмнөх оны мөн үеэс 13.3 хувь буюу 43.7 тэрбум төгрөгөөр буурч 285.0 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний 76.6 хувийг эзэлж байна. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө өмнөх оны мөн үеэс 8.7 хувь буюу 35.4 тэрбум төгрөгөөр буурч 371.8 тэрбум төгрөгт хүрчээ. Бага мөнгөний өсөлтийн хурд өмнөх оны мөн үеийнхээс 9.0 нэгжээр буурчээ. Мөн банкнаас гадуурх мөнгө M2-ийн харьцаа 9.9 хувь болсон нь өнгөрсөн оны мөн үеэс 4.6 нэгжээр бага байна.


2.2 Нөөц мөнгө

Нөөц мөнгө өмнөх оны мөн үеэс 99.4 тэрбум төгрөг (15.7 хувь)-өөр өсч 733.1 тэрбум төгрөгт хүрэв. Тайлант онд Төв банкинд байршуулсан банкуудын харилцах, хадгаламж 134.8 тэрбум төгрөг (59.5 хувь)-өөр өссөн нь нөөц мөнгө өсөхөд нөлөөлсөн байна.

2.3 Гадаад, дотоод цэвэр актив

Гадаад цэвэр актив өмнөх оны эцсээс 849.8 тэрбум төгрөг (124.3 хувь)-өөр өсч 1533.3 тэрбум төгрөг болсон байна. Дотоод цэвэр актив өмнөх оны мөн үеэс 239.8 тэрбум төгрөг (15.1 хувь)-өөр буурч 1346.8 тэрбум төгрөгт хүрэв. Мөнгөний нийлүүлэлтийг байршуулалт талаас нь авч үзвэл нийт мөнгөний 53.2 хувь нь гадаад цэвэр активт, 46.8 хувь нь дотоод цэвэр активт байршиж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад гадаад цэвэр активын M2 мөнгөнд эзлэх хувь нь 23.1 нэгжээр нэмэгдсэн байна. Гадаад цэвэр активын энэхүү өсөлт нь гадаад валютын цэвэр албан нөөцийн өсөлттэй холбоотой.

Зураг 5. Гадаад, дотоод цэвэр актив




Эх сурвалж: Монголбанк, Статистикийн бюллетень

Гадаад валютын цэвэр албан нөөц

Гадаад валютын цэвэр албан нөөц 2009 оны 12 дугаар сарын байдлаар 1145.3 сая ам. долларт хүрч, импортын 28 долоо хоног буюу 7 сарын төлбөртэй дүйцэхүйц байна. Гадаад валютын цэвэр албан нөөц өмнөх оны мөн үеэс 508.0 сая ам.доллар (79.7 хувь)-аар өсчээ.

Зураг 6. Гадаад валютын цэвэр албан нөөц, сая ам. доллар



Эх сурвалж: Монголбанк, Статистикийн бюллетень

Зээл

Дотоодын зээл өмнөх оны эцсээс 19.4 тэрбум төгрөг (0.7 хувь)-өөр өсч 2655.0 тэрбум төгрөгт хүрсэн байна. Банкуудаас хувийн хэвшилд олгосон зээл өнгөрсөн оны мөн үеийнхээс 147.2 тэрбум төгрөг (9.4 хувь)-өөр өсч 1721.0 тэрбум төгрөгт хүрсэн бол улсын салбарт олгосон зээл

14.4 тэрбум төгрөг (41.3 хувь)-өөр буурч 20.4 тэрбум төгрөг, иргэдэд олгосон зээл 108.8 тэрбум төгрөг (10.7 хувь)-өөр буурч 904.9 тэрбум төгрөг, бусад байгууллагад олгосон зээл 4.5 тэрбум төгрөг (34.2 хувь)-өөр буурч 8.7 тэрбум төгрөг тус тус болсон байна. Зээлийн өрийн үлдэгдлийн жилийн өсөлтийн хурд 2008 оны мөн үеийнхээс 27.4 нэгжээр саарчээ.

Хүснэгт 2. Зээл, зээлийн хүү (жил бүрийн 12 дугаар сарын байдлаар, тэрбум төгрөг)

	2005	2006	2007	2008	2009
Нийт зээл	859.9	1,223.3	2,056.1	2,635.6	2,655.0
жилийн өөрчлөлт (%)	41.7	42.3	68.1	28.2	0.7
Төгрөгийн зээлийн хүү	28.3	24.5	19.9	20.4	20.8
жилийн өөрчлөлт (%)	-1.7	-3.8	-4.6	0.5	0.4
Валютын зээлийн хүү	14.8	15.5	14.2	16.8	16.5
жилийн өөрчлөлт (%)	-3.1	0.7	-1.3	2.6	-0.3

Нийт зээлийн үлдэгдлийн 78.0 хувийг хэвийн зээл, 4.6 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 17.4 хувийг чанаргүй зээл тус тус эзэлж байна.

Зураг 7. Зээлийн өрийн үлдэгдэл



Эх сурвалж: Монголбанк, Статистикийн бюллетень

Нийт зээлийг өмчлөгчөөр нь авч үзвэл нийт зээлийн 64.8 хувь нь хувийн хэвшилд, 34.1 хувь нь иргэдэд, 0.8 хувь нь улсын байгууллагад, 0.3 хувь нь бусад байгууллагад олгосон зээл байна.

Зээлийн хүү

Төв банкны үнэт цаасны жигнэсэн дундаж хүү өнгөрсөн оны мөн үеэс 4.0 нэгжээр буурч жилийн 10.82 хувь болсон байна.

Банкуудын төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү² өмнөх оны мөн үеэс 0.4 нэгжээр өсч жилийн 20.8 хувь болсон байна. Валютын зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх оны мөн үеэс 0.3 нэгжээр буурч жилийн 16.5 хувь болжээ. Тайлант онд банкуудаас төгрөгөөр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 9.4-28.8 хувь, валютаар олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 9.9-22.6 хувийн хооронд хэлбэлзэж байв.

3. Мөнгөний зах зээл

Тайлант онд банк хоорондын захын арилжаагаар нийт 316.5 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдсэн бөгөөд үүний 1.2 хувь нь банк хоорондын ухаар олгосон зээл, 5.3 хувь нь репо, 7.6 хувь нь ТБҮЦ-ны хоёрдогч арилжаа, 19.4 хувь нь овернайт зээл, 66.5 хувь нь банк хоорондын

² Зарласан хүү

хадгаламж байна. Эдгээр арилжааны жигнэсэн дундаж хүү жилийн 8.58 хувь байлаа. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү 9.3 нэгжээр буурчээ.

2009 оны 11 дүгээр сарын 18-ны өдрөөс 12 дугаар сарын 15-ны өдрийн хугацаанд банкууд дунджаар төгрөгийн заавал байлгах нөөцөнд 84.8 тэрбум төгрөг, валютын заавал байлгах нөөцөнд 53.3 тэрбум төгрөг байлгах шаардлагыг хангаж ажиллав. Банкууд төгрөгийн заавал байлгах нөөцөнд 108.1 тэрбум төгрөг, валютын нөөцөнд 138.4 тэрбум төгрөг тус тус төвлөрүүлсэн байна.

4. Валютын ханш

Төгрөгийн ам. доллартай харьцах ханш 2009 оны 12 дугаар сарын эцэст 1442.84 төгрөг болж өмнөх оны мөн үеэс 175.3 төгрөг (13.8 хувь)-өөр суларчээ.

МОНГОЛБАНК